

**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД, ЭРҮҮЛ
МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН
ТУШААЛ**

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.1, 7.3.2 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, 8.1.5 дэх заалт, 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг, Эмнэлэгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалт, 13 дугаар зүйл, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7, 9 дүгээр зүйлийн 9.1.3, 9.1.5, 9.1.9 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 37, 38 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Ахмад настанд цогц үнэлгээ хийх, тусламж, үйлчилгээ үзүүлэх журам”-ыг нэгдүгээр, “Ахмад настанд цогц тусламж, үйлчилгээ үзүүлэхэд мэргэжлийн удирдлагаар хангах журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн бодлогын газар (Д.Ренчиндорж), Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын газар (Р.Гантуяа)-т тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар (Ц.Мөнхзул), Эрүүл мэндийн яамны Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)- т тус тус даалгасугай.

САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН

САЙД

Т.МӨНХСАЙХАН

ТАНИЛЦУУЛГА

“Журам батлах тухай” Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалын талаар

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд ахмад настанд цогц үнэлгээ хийж, үнэлгээнд суурилан ахмад настны хам шинж, асран хамгаалал, нийгмийн халамжийн тусламж, үйлчилгээний тулгамдсан асуудлыг эрэмбэлэн хэрэгцээг тогтоож, төлөвлөгөөний дагуу цогц үйлчилгээ үзүүлж, эргэн хянах үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх зохицуулалтыг шинээр тусгасан.

Мөн Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.1-д ахмад настанд цогц үнэлгээ хийх, цогц тусламж, үйлчилгээ үзүүлэх, мэргэжлийн удирдлагаар хангах, үйлчилгээ үзүүлэх иргэн аж ахуйн нэгж байгууллагын сонгон шалгаруулах журмыг нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран баталж, хэрэгжүүлэхээр заасан.

Үүний дагуу хоёр яамны холбогдох, албан тушаалтан, харьяа байгууллагын төлөөллийг оролцуулан дээрх журмуудын төслийг боловсруулах ажлын хэсгийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн А/79 тоот тушаалаар байгуулсан.

Ажлын хэсгийн зүгээс “Ахмад настанд цогц үнэлгээ хийх, үйлчилгээ үзүүлэх журам”, “Ахмад настанд үзүүлэх цогц тусламж, үйлчилгээний мэргэжлийн удирдлагаар хангах журам”, Ахмад настанд үзүүлэх цогц тусламж, үйлчилгээний мэргэжлийн удирдлагаар хангах журам -ын төслийг хамтран боловсруулсан бөгөөд төсөлд дараах гол зохицуулалтыг тусгалаа. Үүнд:

1. “Ахмад настанд цогц үнэлгээ хийх, үйлчилгээ үзүүлэх журам”-ын төсөл нь Нийтлэг үндэслэл, Ахмад настны цогц тусламж, үйлчилгээнд баримтлах зарчим, Ахмад настанд цогц үнэлгээ хийх, Ахмад настанд үзүүлэх үйлчилгээ, Идэвхтэй насжилтийг дэмжих төвийн үйлчилгээ, Асаргааны хувилбарт үйлчилгээ, Ахмад настанд үзүүлэх өдрөөр эмчлэх, сувилах үйлчилгээ, Ахмад настанд үзүүлэх сэргээн засах тусламж, үйлчилгээ, Ахмад настны цогц тусламж үйлчилгээнд тавих хяналт, тайлагналт гэсэн 9 нийт зүйлтэй .

-Уг журмаар эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтан ахмад настны бие бялдар, танин мэдэхүй, сэтгэлзүй, үйл ажиллагааны чадвар, нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлж, хэрэгцээ болон эрсдэлийн зэргийг үнэлэх мэргэжлийн олон талт үйл ажиллагааг хийж, үнэлгээний үр дүнд суурилсан цогц тусламж үйлчилгээг үзүүлэх шинэ тогтолцооны зохицуулалтыг тусгасан.

-Ахмад настны цогц үнэлгээгээр 1 дүгээр түвшин, мөн 2 дугаар түвшний зарим ахмад настанд Идэвхтэй насжилтыг дэмжих төв, Ахмадын ордон, өргөөгөөр Ахмад настны тухай хуулийн 7.1.1-7.1.5, 7.1.9-д заасан үйлчилгээг цогц байдлаар үзүүлэх, мөн үнэлгээгээр 3 дугаар түвшний, шаардлагатай бол 2 дугаар түвшний

ахмад настанд Асаргааны хувилбарт үйлчилгээг журамд заасан төрөл, хэлбэрээр үзүүлэхийг нарийвчлан заасан.

- Мөн эрүүл мэндийн байгууллагаар, Эрүүл мэндийн даатгалын сангийн хөнгөлөлтөөр ахмад настны Өдрөөр эмчлэх сувилах үйлчилгээ, Сэргээн засах үйлчилгээг үзүүлэхийг журмын төсөлд тусгав.

2. “Ахмад настанд үзүүлэх цогц тусламж, үйлчилгээний мэргэжлийн удирдлагаар хангах журам”-ын төсөлд дараах зохицуулалтыг тусгав .

- Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан үйлчилгээг хэрэгжүүлэхэд салбар дундын үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтныг мэргэжил арга зүйн удирдлагаар хангахад дэмжлэг үзүүлэх, чиглүүлэх үүрэг бүхий 9 хүний бүрэлдэхүүнтэй Удирдах хороог нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний дэргэд ажиллуулна. Удирдах хорооны шийдвэрийг хэрэгжүүлэх, өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулах үүрэг бүхий 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын алба ажиллах;

-Сум, хорооны эрүүл мэндийн төв, нийгмийн ажилтны ахмад настанд үзүүлэх үйлчилгээ, урт хугацааны тусламж, үйлчилгээ түүний дотор идэвхтэй насжилтын төвүүдийг орон нутагт хөгжүүлэх, хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлж, чиглүүлж ажиллах үүрэг бүхий Орон нутгийн удирдах хороог аймаг, дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулан аймаг, дүүргийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга удирдана.

- Журмын төсөл нь 5 зүйлтэй бөгөөд Ахмад настны тухай хуульд заасны дагуу ахмад настны цогц үнэлгээ хийж, цогц тусламж үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагуудын удирдлага, зохион байгуулалт, чиг үүрэг, тухайн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтныг мэргэшүүлэх, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн удирдлагыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусган боловсруулав.

---oOo---

Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2024 оны .. дугаар сарын ...-ны өдрийн хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралт

АХМАД НАСТАНД ЦОГЦ ҮНЭЛГЭЭ ХИЙХ, ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Ахмад настны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7, 4.1.8 дахь заалт, 7 дугаар зүйлд заасны дагуу ахмад настны бие бялдар, танин мэдэхүй, сэтгэлзүй, үйл ажиллагааны чадвар, нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлох цогц үнэлгээ хийж, тулгамдсан асуудлыг эрэмбэлэн тогтоож, хэрэгцээнд суурилсан цогц тусламж, үйлчилгээ үзүүлэх, хяналт тавихад энэхүү журмыг баримтална.

1.2.Ахмад настанд цогц тусламж, үйлчилгээг Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Ахмад настны тухай, Нийгмийн халамжийн тухай, Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн үзүүлнэ.

Хоёр. Ахмад настны цогц тусламж, үйлчилгээнд баримтлах зарчим

2.1.Ахмад настны цогц тусламж, үйлчилгээнд дараах зарчмыг баримтална:

- 2.1.1.хүний эрхийг дээдлэх, хувь хүний нэр төрд хүндэтгэлтэй хандах;
- 2.1.2.хувийн онцлог хэрэгцээ, сэтгэл зүй, шашин шүтлэг, зан заншлыг хүндэтгэх;
- 2.1.3.үл ялгаварлах, хараат бус байдлыг хүндэтгэх;
- 2.1.4.хувь хүн, гэр бүлийн нууцыг хадгалах;
- 2.1.5.хүчирхийлэл, үл хайхрах байдлаас хамгаалах;
- 2.1.6.нийгмийн амьдралд оролцох оролцоог дэмжих;
- 2.1.7.гэр бүл, нийгэм, олон нийтийн оролцоонд түшиглэсэн байх;
- 2.1.8.мэргэжлийн, чанартай, ил тод, хүртээмжтэй байх.

Гурав. Ахмад настанд цогц үнэлгээ хийх

3.1.Ахмад настны цогц үнэлгээг өрхийн, сум, тосгоны эрүүл мэндийн төв (багийн эмчийн салбар)-ийн Эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6-д заасан эрүүл мэндийн ажилтан хийнэ.

3.2.Эрүүл мэндийн ажилтан Ахмад настны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7-д заасан ахмад настны цогц үнэлгээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан “Ахмад настанд үзүүлэх тусламж, үйлчилгээний заавар”-ын дагуу дараах 6 чадвараар үнэлнэ:

- 3.2.1. танин мэдэхүйн чадвар бууралтын үнэлгээ;
- 3.2.2. хөдөлгөөний чадвар бууралтын үнэлгээ;
- 3.2.3. хоол тэжээлийн бууралтын үнэлгээ;
- 3.2.4. харааны чадвар бууралтын үнэлгээ;
- 3.2.5. сонсголын чадвар бууралтын үнэлгээ;
- 3.2.6. сэтгэл гутралын үнэлгээ.

3.3. Энэ журмын 3.2-т заасан ахмад настны цогц үнэлгээгээр 1 дүгээр түвшин буюу “эрүүл, идэвхтэй ахмад настан” (цаашид “1 дүгээр түвшин” гэх), 2 дугаар түвшин буюу “бага зэргийн тусламж, үйлчилгээ шаардлагатай ахмад настан” (цаашид “2 дугаар түвшин” гэх), 3 дугаар түвшин тусламж, үйлчилгээ зайлшгүй шаардлагатай ахмад настан (цаашид “3 дугаар түвшин” гэх) гэж ангилан, тохирох үйлчилгээнд хамруулна.

3.4. Сум, хорооны нийгмийн ажилтан энэ журмын 3.2-т заасан ахмад настны цогц үнэлгээгээр 1, 2 дугаар түвшинд үнэлэгдсэн ахмад настанд зөвлөгөө өгч, идэвхтэй насжилтыг дэмжих төв, Ахмадын ордон, өргөө, хөгжлийн төвийн эсхүл үйлчилгээ үзүүлэхээр гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаас үзүүлж буй үйлчилгээнд хамруулна.

3.5. Сум, хорооны нийгмийн ажилтан, энэ журмын 3.1-д заасан эрүүл мэндийн ажилтан 3 дугаар түвшний ахмад настанд болон шаардлагатай бол 2 дугаар түвшний ахмад настанд нийгмийн тулгамдсан асуудал, хэрэгцээний, эрсдэлийн зэргийн үнэлгээ болон эрүүл мэндийн хам шинжийн бууралтыг лавшруулан үнэлнэ.

3.6. Сум, хорооны нийгмийн ажилтан болон энэ журмын 3.1-д заасан эрүүл мэндийн ажилтан энэ журмын 3.5-д заасан үнэлгээнд үндэслэн 3 дугаар түвшний, шаардлагатай бол 2 дугаар түвшний ахмад настанд эмнэлгийн тусламж, үйлчилгээний, нийгмийн халамжийн, ахмад настны цогц тусламж үйлчилгээний, бусад шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах үйл ажиллагааны төлөвлөгөө гарган, хэрэгжүүлж, эргэн хянана.

3.7. Ахмад настны цогц үнэлгээнд ахмад настан сайн дурын үндсэн дээр хамрагдах бөгөөд уг үнэлгээг цахимаар хийлгэж болно.

Дөрөв. Ахмад настанд үзүүлэх үйлчилгээ

4.1. Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан үйлчилгээг аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагатай гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага, ахмадын өргөө болон сэргээн засах, идэвхтэй насжилтыг дэмжих төв, гэр бүлийн хөгжлийн төвөөр үзүүлнэ.

4.2. Ахмад настны тухай хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.5, 7.1.9, 7.1.10, 7.1.11-д заасан эрүүл, идэвхтэй насжилтийг дэмжих үйлчилгээг 1, 2 дугаар түвшний ахмад настанд үзүүлнэ.

4.3. Ахмад настны тухай хуулийн 7.1.3, 7.1.4 болон 7.1.7-д заасан үйлчилгээнд 3 дугаар түвшний, шаардлагатай бол 2 дугаар түвшний ахмад настныг хамруулна. 3 дугаар түвшний ахмад настны өөрийн нь хүсэлтийн дагуу хэрэгцээ шаардлага, бие

даах чадварын түвшинг харгалзан энэ журмын 4.2-д заасан үйлчилгээнээс тохирох үйлчилгээнд хамруулж болно.

4.4.Ахмад настны тухай хуулийн 7.1.6, 7.1.12-т заасан үйлчилгээг ахмад настанд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн баталсан тогтоолын дагуу сум, тосгоны эмнэлэг, өрхийн эмнэлэгээр үзүүлнэ.

4.5.Ахмад настны тухай хуулийн 7.1.12-т заасан үйлчилгээг ахмад настанд сэргээн засах амбулаторийн, сэргээн засах өдрийн тусламж, үйлчилгээний багцаар, сэргээн засах хэвтүүлэн эмчлүүлэх хэлбэрээр үзүүлж, зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ.

Тав.Ахмад настны идэвхтэй насжилтийг дэмжих төвийн үйлчилгээ

5.1.Идэвхтэй насжилтийг дэмжих төвийн үйлчилгээг ахмадын өргөө, ордон, идэвхтэй насжилтыг дэмжих төв, гэр бүлийн хөгжлийн төвөөр 1, 2 дугаар түвшний ахмад настанд үйлчилгээг үзүүлнэ.

5.2.Идэвхтэй насжилтийг дэмжих төвийн үйлчилгээг ахмадын өргөө, ордон, идэвхтэй насжилтыг дэмжих төв, гэр бүлийн хөгжлийн төвөөр үзүүлэхдээ тухайн орон нутаг нөөц боломжийг тодорхойлж, зураглал гарган, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, олон талын оролцоог хангасан байдлаар үзүүлнэ.

5.3.Идэвхтэй насжилтийг дэмжих төвийн үйлчилгээнд дараах үйлчилгээг хамруулна:

5.3.1.лавлагаа, мэдээллийн үйлчилгээ;

5.3.2.ахмад настны хөгжлийн үйлчилгээ;

5.3.3.ахмад настны зөв хооллолт, дасгал, хөдөлгөөн, эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ;

5.3.4.зөвлөгөө өгөх;

5.3.5.сайн дурын үйлчилгээ;

5.3.6.гэр бүлийн хүчирхийллээс хамгаалагдах үйлчилгээ.

5.4.**Лавлагаа, мэдээлэл, чиглүүлэх үйлчилгээг** энэ журмын 5.1-д заасан төвийн нийгмийн ажилтан дараах байдлаар үзүүлнэ:

5.4.1.ахмад настны нөхцөл байдлыг үнэлэн, үйлчилгээний хэрэгцээг үнэлэх, тодорхойлох;

5.4.2.ахмад настны хэрэгцээ, сонирхолд нийцсэн эрүүл мэнд, нийгмийн халамж, хууль эрхзүйн үйлчилгээний талаар мэдээлэл өгөх;

5.4.3.ахмад настанд нэн шаардлагатай үйлчилгээний болон байгууллага, хөтөлбөрийн талаар мэдээллийн сан бүрдүүлж, хялбар ойлгомжтой байдлаар танилцуулга, гарын авлага бэлтгэн, цахим болон цаасан хэлбэрээр хүргэх;

5.4.4.ахмадуудад тулгарч буй асуудалд шаардлагатай мэргэжлийн ажилтан зөвлөгөө өгөх;

5.4.5.холбогдох байгууллагын хаяг, холбоо барих мэдээллийг лавлагаа болгон өгөх;

5.4.6.ахмад настны хэрэгцээг тодорхойлж, шаардлагатай газарт

(эрүүл мэндийн байгууллага, нийгмийн халамжийн байгууллага, хууль зүйн зөвлөгөөний төв г.м) холбон зуучлах;

5.4.7.цахим платформ, аппликэйшн ашиглан ахмадуудтай харилцах, мэдээлэл түгээх;

5.4.8.ахмадуудыг идэвхтэй оролцуулах уулзалт, арга хэмжээ зохион байгуулах;

5.4.9.ахмад настны санал бодлыг тусган үйлчилгээний чанарыг сайжруулах;

5.4.10.мэдээллийн хэрэгцээ, шаардлагатай үйлчилгээний төрлөөр нь холбогдох зөвлөгөө, мэдээлэл авахад чиглүүлэх, дэмжлэг үзүүлэх;

5.4.11.тэдний асран хамгаалагчдыг шаардлагатай үйлчилгээ, бодит нөөц боломжуудтой холбох;

5.4.12.үйлчилгээний хэрэгжилтэд хяналт тавих, шаардлагатай үйлчилгээг санал болгох, эсвэл зогсоох;

5.4.13.идэвхтэй насжилт, асрамж үйлчилгээ, кэйс менежментийн үйлчилгээг үзүүлэхэд бусад байгууллагуудтай харилцан уялдаа холбоотой ажиллах;

5.4.14.ахмад настныг урт хугацаанд өөрийн хөгжил, эрүүл мэнд сайн сайхан байдлаа хадгалах талаар сургалтанд хамрагдах, төлөвлөгөө гаргах, өөрийн менежмент хийхэд мэргэжлийн дэмжлэг туслалцаа үзүүлэх.

5.5.Ахмад настныг нийгмийн харилцаанд идэвхтэй оролцуулах, соёл, урлаг, спортын арга хэмжээнд хамруулах, орчин үеийн техник хэрэгсэл ашиглах, сурч хөгжихөд чиглэсэн **хөгжлийг дэмжих үйлчилгээг** дараах хэлбэрээр үзүүлнэ:

5.5.1.**оюун ухаан сэргээх дасгал:** шатар, даам, даалуу, хөзөр, эвлүүлдэг тоглоом, сэтгэхүй хөгжүүлэх тоглоом тоглох, баруун, зүүн тархины үйл ажиллагааг сэргээх зураг зурах, будах, үгийн сүлжээ бөглөх;

5.5.2.**чадавхжуулах сургалт:** хууль эрх зүй, гадаад хэл, монгол бичгийн сургалт явуулах, нэхмэл, чимэглэл, шүр хэлхэх, гар доорх материал ашиглан бүтээл урлах, бэлэг дурсгалын зүйл хийх, мод, цэцэг, тариалах, төрөл бүрийн нарийн боов, хоол хийх, гэрэл зураг авах, эдийн засгийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулах, жижиг бизнес эрхлэх сургалтууд, насан туршийн боловсролын хөтөлбөрт ахмадуудыг хамруулах, сургагч багш бэлтгэх, “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”, “Ахмад настны тэтгэвэрт бэлтгэх хөтөлбөр”-ийг танилцуулах ажлыг зохион байгуулах;

5.5.3.**технологийн сургалт:** орчин үеийн техник хэрэгсэл, компьютер, гар утас, гэр ахуйн цахилгаан хэрэгсэл ашиглах сургалт, банк, имонголиа, төрийн үйлчилгээний цахим систем, гар утас апплекейшнаар дамжуулан үйлчилгээ авч сурах, цахим үйлчилгээнд хамрагдахад зөвлөх, чиглүүлэх, хол амьдарч байгаа хүүхэдтэйгээ цахимаар холбогдоход дэмжлэг үзүүлэх, туслах хэрэгсэл ашиглаж сургах;

5.5.4.**соёл амралт:** хөгжөөнт буухиа тоглоом дуу, хөгжмийны хичээл, кароке, номын сангаар үйлчлэх, /ном сонин унших, сонсдог ном, цахим ном /, аялал зугаалга, төрөл бүрийн өдөрлөг зохиох;

5.5.5.**нийгмийн оролцоо:** ганцаардлыг даван туулах, урамшуулах, дэмжих, олон нийтийн үйл ажиллагаанд оролцуулах, ахмад залуу үеийн холбоог бэхжүүлэх, түүх, туршлага, сургамжаа хуваалцах, гэр бүл, үе хоорондын уулзалт, арга хэмжээ /ач зээ үр хүүхэд эмээ өвөө / зохион байгуулах, соёлын дурсгалт

газар, цэцэрлэгт хүрээдэнд өдөрлөг зохион бйагуулах, байгальд ээлтэй, байгаль хамгаалах үйл ажиллагаанд оролцох, мод, цэцэрлэгжүүлэлтэд оролцох;

5.5.6.хувь хүний хөгжил: хувь хүний онцлог, давуу тал, хүсэл мөрөөдөл, санаа зовоосон асуудал зэрэгтээ гол анхаарлаа хандуулж, хувийн нөхцөл байдлаа сайжруулах чадвараа хөгжүүлэхэд туслах, амьдралын буруу хэв маяг, зан үйлээ өөрчлөхөд нь дэмжих, ур чадвар, туршлагаа харилцан хуваалцах сургалт зохион байгуулах;

5.5.7.бүлгийн зохион байгуулалт: ойролцоо асуудал, туршлагатай хүмүүс нэг бүлэг болж, өөрсдийн асуудлаа хуваалцах, итгэл үнэмшлээ нэмэгдүүлэхэд туслах зорилгоор дэмжих бүлэг үүсгэх, бүлэгт нэгдэхийг урамшуулах.

5.6.Ахмад настны зөв хооллолт, дасгал, хөдөлгөөн, эрүүл мэндийг дэмжих үйлчилгээг дараах хэлбэрээр үзүүлнэ:

дасгал хөдөлгөөн: биеийн тамир, дасгал хөдөлгөөн, аэробик, иог, явган аялал, алхалтын клуб, дугуйлан, онлайн хичээлээр дамжуулан эрүүлжүүлэх, зөв суух, алхах зэрэг хөдөлгөөний эвслийг сайжруулах, түүнчлэн сэтгэл зүйг дэмжих зорилгоор бүжиг, дасгал хийх;

5.6.2.шим тэжээлийн талаарх ойлголт: жимс, хүнсний ногооны ач тус түүний хэрэглээ, эрүүл хоол хийх хичээл, хоолны дэглэм төлөвлөлт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сургалт, мэдээлэл өгөх;

5.6.3.стресс менежмент: иог, бясалгал хийх, сэтгэлзүйн зөвлөгөөг ганцаарчилсан, бүлгийн, хосын, гэр бүлийн хүрээнд өгөх, стресс тайлах энгийн аргуудад сургах, харилцаа хандлага, настны сэтгэл зүйн онцлог сургалт хийх ;

5.6.4.нийгмийн эрүүл мэндийн сургалт: цусны даралт ихсэх өвчин, чихрийн шижин, ясны сийрэгжилт, зөнөгрөх өвчнөөс урьдчилан сэргийлэх, идэвхтэй дасгал хөдөлгөөний сургалт, асаргаа шаардлагатай ахмад настны асран хамгаалагчдад Улаан загалмайн нийгэмлэг, анхан шатны нэгжийн сайн дурынхан, Анагаах ухаан, сувилахуйн сургуулийн багш оюутнуудаар асаргаа сувилгааны онол, практикийн сургалт, дадлага хийлгэх, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх;

5.6.5.орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын талаарх ойлголт: орон зай, хараа, хүртэхүйн мэдрэмжийн талаарх сургалт хийх.

5.7.Ахмад настанд зөвлөгөө өгөх үйлчилгээг энэ журмын 5.1-д заасан төвийн нийгмийн ажилтан, эрүүл мэндийн ажилтан, хуульч, сэтгэл зүйч, эдийн засагч зэрэг мэргэжилтэн (төв нь мэргэжлийн ажилтангүй бол гэрээгээр ажиллуулж болно) дараах байдлаар үзүүлнэ:

5.7.1. ахмад настанд гэр бүл, нийгмийн харилцаа, ганцаардал, стресс, өөртөө итгэх итгэлийг сэргээх, амьдралын зорилгоо тодорхойлох, бүлгийн сэтгэл зүйн уулзалт, ярилцлагад хамруулах чиглэлээр сэтгэл зүйн зөвлөгөө өгөх;

5.7.2.ахмад настанд тэтгэвэр, тэтгэмж, өмч, хөрөнгийн эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх, гэрээслэл, гэрээний эрх зүй, гэр бүлийн хүчирхийлэл болон бусад хууль зүйн үйлчилгээний талаар зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллагад зуучлах;

5.7.3.ахмад настанд хорт хавдар, архаг болон бусад өвчний үеийн дэглэм, хоол, ахуйн зохицуулалт, эрүүл амьдралын хэв маягыг хэвшүүлэх, эрүүл хооллолт, дасгал хөдөлгөөн, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, үзлэг шинжилгээнд

хамрагдах зэрэг асуудлаар зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллагад зуучлах;

5.7.4.нийгмийн халамж, нийгмийн даатгал, хөдөлмөр эрхлэлтийн үйлч ажиллагаа, төсөл хөтөлбөрт хамрагдах, оролцох талаар мэдээлэл зөвлөгөө өгөх, дэмжих, шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллагад зуучлах;

5.8.Ахмад настанд туслах хүсэл сонирхолтой иргэн, байгууллага **сайн дурын үйлчилгээг** дараах хэлбэрээр зохион байгуулна:

5.8.1.үнэлгээгээр 3 дугаар түвшний ахмад настанд гэрийн ажил, хоол хийх, усанд оруулах, эмнэлэгт үзүүлэх, банкаар орох, хүнс, бараа худалдан авах, гэрийн засвар үйлчилгээ, гэр нүүлгэлт гэх мэт үйл ажиллагаанд туслах;

5.8.2.үнэлгээгээр 3 дугаар түвшний ахмад настанд ахмад настны хүмүүсийн сэтгэл санааг дэмжих, ганцаардлыг арилгах зорилгоор хамт цагийг өнгөрөөх, ярилцах, ном, сонин, сэтгүүл уншиж өгөх, гадаа явган алхахад нь туслах, тэргэнцэртэй хүнийг салхилуулах;

5.8.3.ахмад настанд эрүүл мэндийн мэдлэг, зөвлөгөө өгөх, эмнэлгийн үйлчилгээний талаар зөвлөмж өгөх, биеийн тамирын дасгал хийлгэх ахмад настанд хобби, урлаг, гараар хийх зүйлсийн сургалт, хөгжмөөр дамжуулан сэтгэл санааг нь сэргээх, компьютер, интернэт ашиглах сургалт явуулах, баяр ёслол, соёл урлагийн тоглолт, аялал зохион байгуулах, нийгмийн оролцоог дэмжих зорилгоор төрөл бүрийн үйл ажиллагаа, төсөл хэрэгжүүлэх;

5.8.4.нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай ахмад настанд өгөх хувцас, хүнс, зэргийг төвд цуглуулах, тараах, хандивын хайрцаг ажиллуулах, аян зохион байгуулах, төвд усанд оруулах, үс засах, сайн дурын байгууллагын эмчийн үзлэгт хамруулах, ахмад настны асрамжийн газарт ажиллах гэх мэт үйл ажиллагааг холбогдох байгууллагуудтай зохион байгуулах.

5.9.Ахмад настан өөрсдийн санаачлагаар сайн дурын ажилд оролцох үйлчилгээ нь дараах байдлаар үзүүлнэ:

5.9.1.залуу үе, бусдад өөрийн амьдралын туршлага, мэдлэгээ хуваалцах, зөвлөгөө өгөх, сургалт кохион байгуулах тухайлбал багш байсан бол түүх, гадаад хэл, эсвэл гар урлал, уран зураг гэх мэт сургалт зохион байгуулах, эмч сувилагч байсан бол эрүүл мэндийн зөвлөгөө, дасгал, хөдөлгөөн, эрүүл хооллолтын зөвлөгөө, сургалт хийх;

5.9.2.ахмад настан хоцрогдолтой хүүхдэд хичээл заах, давтуулах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах, хүүхдийн асрамжийн газар цагаар ажиллах;

5.9.3.олон нийтийн ажил зохион байгуулах, оролцох, бусдад хоол хүнс хүргэх, тусламж хэрэгтэй хүмүүст үйлчилгээ үзүүлэх, хандив өргөх, хямд үнээр бараа худалдах зэргээр нийгмийн амьдралд идэвхтэй оролцож, бусад хүмүүст эерэг нөлөө үзүүлэх;

5.9.4.амьдралын туршлага, мэдлэгийг хуваалцах замаар залуу үед сургууль, хичээлийн танхимд сургалт, мэдээлэл хийх, зөвлөх, гэр бүл, найз нөхөд, залуу хосуудад зөвлөмж өгөх, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх, хүнд үеийг даван туулахад туслах;

5.9.5.биеийн тамир, спортын мэдлэг, ур чадвар, туршлагаа бусдад дасгал хөдөлгөөн хийх, спортын тэмцээн, фитнесс хичээл, бүжиг зэргийг бусдад зааж, идэвхтэй амьдралын хэв маяг түгээх;

5.9.6.ахмад настан эмнэлэг, асрамжийн газар, номын сан, музей, аялал жуулчлалын бүс, цэцэрлэгт хүрээлэн, хүүхдийн парк зэрэг байгууллага, сургууль, гэр орчмын замын хөдөлгөөнийг зохицуулах, цэцэрлэгжүүлэлт, орчны тохижилт хийх зэрэг ажилд сайн дураар туслах.

5.9.7.идэвхтэй насжилтийг дэмжих төвийн үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, байгууллага нь сайн дурын ажил, үйлчилгээ үзүүлсэн байгууллага, иргэн, хүүхэд, залууст сертификат олгох, мэдээллийн сан үүсгэхгээс гадна үйлчилгээний аюулгүй байдлыг хангах.

5.10.Идэвхтэй насжилтыг дэмжих төвийн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллага нь ахмад настанд гэр бүлийн хүчирхийллээс хамгаалагдах үйлчилгээг дараах хэлбэрээр зохион байгуулна:

5.10.1.хүчирхийлэлд өртсөн ахмад настнуудыг илрүүлэх, хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, ахмад настанд эрх, хууль зүйн хамгаалалт, тусламжийн үйлчилгээний тухай мэдээлэл хүргэх;

5.10.2.сэтгэл зүйн хямралд орсон ахмад настантай ярилцах, сэтгэл санааг дэмжих үйлчилгээ үзүүлэх;

5.10.3.ахмад настанг санхүүгийн боловсролтой болох, аюулгүй байдлыг хангах талаар сургалт зохион байгуулах, санхүүгийн байдал, тэтгэвэр, хэрэглээний талаар мэдээлэл авах;

5.10.4.учирч буй аюул занал, асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай нөөцийг хангах, түүний дотор нийгмийн үйлчилгээ, хууль зүйн мэргэжилтнүүдтэй холбох;

5.10.5.гэр бүлийн бусад гишүүдтэй ажиллаж, асуудлыг илрүүлж, ахмад настныг дэмжих арга хэмжээг зохион байгуулах;

5.10.6.ахмад настан аюултай нөхцөлд байгаа бол хамтарсан багт мэдэгдэх, аюулгүй орчинд хамгаалах байр зэрэгт шилжүүлэх.

5.11.Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн ахмад настныг илрүүлэхдээ хөхрөлт, шарх, гэмтэл зэрэг биеийн гэмтэл, сэтгэл гутрал, нийгмийн харилцаанд орохоос зайлсхийх зэрэг сэтгэл зүйн өөрчлөлт, эмнэлгийн тусламж авах боломжийг хязгаарлах, бие даан амьдрах боломжгүй болгох зэрэг бусдаас тусгаарласан байдалд ажиглалт хийнэ.

5.12.Энэ журмын 5.11-д заасан ажиглалтаас ахмад настныг хүчирхийлэлд өртсөн, өртсөн байж болзошгүй гэж үзвэл төрийн, төрийн бус байгууллагын ажилтан, хуулийн этгээд, бусад этгээд цагдаагийн байгууллагад, цагдаагийн алба хаагчийн эзгүйд сум, баг, хорооны Засаг даргад болон мэдээлэнэ.

5.13.Идэвхтэй насжилтийг дэмжих төвийн үйлчилгээг үзүүлэхдээ төв нь орон тооны мэргэжлийн нийгмийн ажилтан, зохион байгуулагчтай байна.

5.14.Идэвхтэй насжилтийг дэмжих төвийн үйлчилгээг үзүүлэхдээ төв нь хөгжлийн үйлчилгээний сургагч багш, эрүүл мэндийн ажилтан, хуульч, сэтгэл зүйч зэрэг мэргэжилтнийг гэрээгээр, цагаар авч ажиллуулж болно.

5.15. Энэ журмын 5.14-т заасан гэрээт мэргэжилтэн нь ахмад настан бол Ахмад настны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т заасан Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төлөвлөгөөнд тусгаж, цалин хөлсийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлнэ.

5.16.Энэ журмын 5.5.2, 5.5.3, 5.6-д заасан сургалтыг харьяа аймаг, дүүргийн Насан туршийн боловсролыг дэмжих төвийн багш нарын оролцоотой зохион байгуулах, сургалт хийх багш бэлтгэх зорилгоор ахмад настанг тус төвийн хөтөлбөр, сургалтад хамруулах арга хэмжээ авна.

5.17.Нийгмийн ажилтан, зохион байгуулагч энэ журмын 5.2-т заасны дагуу орон нутгийн нөөцийг тодорхойлж, зураглал гарган, сайн дурын ажилтан, гэрээт ажилтан, бусад байгууллагын оролцоог хангаж, тухайн орон нутгийн нийт ахмад настанд чанартай, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлнэ.

Зургаа. Ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээ

6.1.Асаргааны хувилбарт үйлчилгээг 3 дугаар түвшний, шаардлагатай бол 2 дугаар түвшний ахмад настанд, түүний нийгмийн тулгамдсан асуудал, нөхцөл байдал, эрсдлийн зэргийн үнэлгээ болон эрүүл мэндийн хам шинжийн бууралтыг үндэслэн улс, орон нутгийн асрамжийн газар, иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар үзүүлнэ.

6.2.Энэ журмын 6.1-д заасан байгууллагын нийгмийн ажилтан, эмч зэрэг мэргэжлийн баг буюу кейс менежментийн баг ахмад настны цогц үнэлгээний үндсэн дээр тухайн ахмад настанд үзүүлэх кейс менежментийн үйлчилгээний төлөвлөгөөг боловсруулж, төлөвлөгөөний дагуу тохирох асаргааны хувилбарт үйлчилгээнд хамруулан, эргэн хянана.

6.3.Асаргааны хувилбарт үйлчилгээ нь дараах төрөлтэй байна:

6.3.1.гэрээр асрах үйлчилгээ;
6.3.2.өдрөөр асрах үйлчилгээ;
6

. 6.3.4.түр хугацаагаар асрах үйлчилгээ;
3 6.3.5.урт хугацаагаар асрах үйлчилгээ;
. 6.3.6.байнга асрах үйлчилгээ;
3 6.3.7.төрөлжсөн асрамжийн үйлчилгээ.
.

а **6.4.Гэрээр асрах үйлчилгээг** 3 дугаар түвшний шаардлагатай бол 2 дугаар түвшний ахмад настны өдөр тутмын амьдралд дэмжлэг үзүүлэх, тэдний амьдралын ранарыг сайжруулахад ахмад настны гэрт нь очиж, хувийн арчилгаа, ахуйн тусламж, үйлчилгээг дараах хэлбэрээр үзүүлнэ:

л 6.4.1.өдөр тутмын ахуйн үйл ажиллагаанд туслах: хоол хүнс бэлтгэх, дэлгүүрээс хүнс, бараа худалдан авахад дэмжлэг үзүүлэх, гэр орны цэвэрлэгээ, угаалга, хувцас индүүдэх зэрэг ажлыг гүйцэтгэх, хувийн ариун цэврийг сахихад туслах (усанд оруулах, шүд, гар нүүр угаах, хувцас өмсгөх гэх мэт), хооллох, бие

э
р

б
v

засуулах, мод түлээ хагалах, ус авах, зэргээр бие даан амьдрахад хүндрэлтэй ахмадуудад аюулгүй, тав тухтай орчин бүрдүүлэх;

6.4.2.нийгмийн харилцааг дэмжих: гэрээс гарах боломжгүй ахмад настанд ганцаардлаас сэргийлж, харилцан ярилцаж, сэтгэл санааг нь дэмжих, гэр бүлийнхэн, найз нөхөдтэй нь холбоо барихад туслах, ном, сонин унших, гар, хөлийн хөдөлгөөн сайжруулахад туслах, гэрээс гарах боломжийг хангах, захиргаа, банк зэрэг байгууллагад үйлчлүүлэхэд туслах, олон нийтийн арга хэмжээнд оролцоход дэмжлэг үзүүлэх, сэргээн засалт, сувиллын газар, ахмадын төвд хүргэж өгөх, гэрийн орчны аюулгүй байдлыг шалгах (цахилгаан хэрэгсэл, шат гишгүүрийн аюулгүй байдал гэх мэт), осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх зөвлөгөө өгөх, хэрэгцээт бараа бүтээгдэхүүнийг захиалах, хүргүүлэхэд туслах, байгууллага, үйлчилгээний газруудтай холбогдож, асуудлыг шийдвэрлэхэд зуучлах;

6.4.3. энэ журмын 6.1-д заасан байгууллагын гэрээр асрах үйлчилгээ үзүүлэх ажилтан нь мэргэжлийн ур чадвартай, сургалтад хамрагдсан, гэмт хэрэгт холбогдож байгаагүй, хорт муу зуршилгүй, ахмад настны хувийн орон зай, эрхийг хүндэтгэх, хэрэгцээ, онцлогийг ойлгох, ёс зүйн дүрэм баримталдаг, гэр бүл, төрөл, садантай холбоотой байх.

6.5.”Ахмад настныг өдрөөр асрах үйлчилгээ”-г 3 дугаар түвшний шаардлагатай бол 2 дугаар түвшний гэртээ ганцаар үлдэх боломжгүй, оюуны ялгаатай хөгжил, сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай, зөнөгрөх өвчтэй, байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг төв эсхүл өөрийн байранд авчран ахмад настны хэрэгцээнд тохирсон асаргаа, үйлчилгээг дараах хэлбэрээр үзүүлнэ:

6.5.1.өдрөөр асрах үйлчилгээний хугацаа, үйлчлүүлэгчийн хооллолт, үзүүлэх асаргаа, сувилгааны үйлчилгээний төрөл, хэлбэрийг түүний эрүүл мэндийн байдал, хэрэгцээ шаардлагад үндэслэн боловсруулж, хувь хүний хөтөлбөрийн дагуу асаргаа үйлчилгээний болон хөгжлийн үйлчилгээ үзүүлэх;

6.5.2.өдөр тутмын арчилгаа: хооллох, хувцаслах, ариун цэвэр сахихад туслах, хэвтрийн горимд байгаа ахмадуудыг шилжүүлэн байрлуулах, хөдөлгөөнд дэмжлэг үзүүлэх, тэргэнцэр ашиглах;

6.5.3.асаргаа, сувилгааны үйлчилгээ: хөнгөн дасгал хөдөлгөөн, физиотерапи, хөдөлгөөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, ахмад настны биеийн болон оюун санааны үйл ажиллагааг идэвхжүүлэх, эм уух цагийг хянах, биеийн байдлыг хянах, шаардлагатай тохиолдолд анхны тусламж үзүүлэх;

6.5.4.сэтгэл санааны дэмжлэг: тусгайлан бэлтгэгдсэн ажилтнууд ахмад настануудтай ярилцаж, сэтгэл санааг нь дэмжих, бие даан сонирхож буй үйл ажиллагааг дэмжих (ном унших, зураг зурах), ганцаардах мэдрэмжийг бууруулах зорилгоор бүлгийн үйл ажиллагаа зохион байгуулах.

6.6.Өдрөөр асрах үйлчилгээ үзүүлэх байгууллага нь хүсэлт гаргасан ахмад настан, түүний асран хамгаалагчтай харилцан тохиролцож, үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулна.

6.7.Өдрийн үйлчилгээг оюуны ялгаатай хөгжил, сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай, зөнөгрөх өвчтэй ахмад настанд тусгай төрөлжсөн мэргэшлийн эмчийн заавар, удирдлага, хяналтын дор үзүүлнэ.

6.8.Асралт гэр бүлээр асрах үйлчилгээг тэжээн тэтгэх хүүхэдгүй, ганц бие 3 дугаар түвшний, шаардлагатай бол 2 дугаар түвшний ахмад настанг гэр бүлдээ авч асран халамжлахаар зөвшөөрч, тодорхой шалгуурын дагуу сонгогдон, аймаг,

дүүргийн нийгмийн халамжийн байгууллагатай “Ахмад настныг асран халамжлах гэрээ” байгуулж асран халамжлах үйлчилгээ үзүүлнэ:

6.8.1.асралт гэр бүлийн үйлчилгээ үзүүлэх иргэний хүсэлт, гэр бүлийн мэдээллийг аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтан бүртгэн авч, нөхцөл байдлын үнэлгээ хийж, ахмад настныг асрах орон байр, орчин нөхцөл, өрхийн орлогын түвшин, гэр бүлийн гишүүдийн амьдралын хэв маяг, зан үйл, сэтгэл зүйн байдлыг судалж, үйлчилгээ үзүүлэх шаардлага хангах эсэх талаар дүгнэлт гаргах;

6.8.2.энэ журмын 6.8.1-д заасан гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ, дүгнэлтээр асралт гэр бүлийн үйлчилгээ үзүүлэх боломжтой талаар дүгнэлт гарсан тохиолдолд тухайн гэр бүлд ахмад настныг хүлээлгэн өгч, нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтан, ахмад настныг асралт гэр бүлээр асруулах тухай гурвалсан гэрээ байгуулах;

6.8.3.ахмад настныг асарч буй асралт гэр бүлд Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.3-т заасан асаргааны тэтгэмжийг сар бүр олгох;

6.8.4.нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтан нь асран халамжлуулах ахмад настанд асран халамжлах үйлчилгээ болон гэр бүлийн орчинд халамжлуулахын ач холбогдлыг ойлгуулах;

6.8.5.асралт гэр бүлийн үйлчилгээ үзүүлэгч иргэн, түүний гэр бүлийн гишүүд ахмад настанд эрүүл, аюулгүй орчинд гэр бүлийн халуун, дулаан уур амьсгалыг мэдрүүлэх, хүндэтгэлтэй хандах, асран халамжлах үйлчилгээг үзүүлэх үүрэг хүлээх;

6.8.6.асралт гэр бүлийн үйлчилгээ үзүүлэгч иргэн, гэр бүлийн гишүүдийг ахмад настныг асрах, хувийн орон зайг хүндэтгэх, гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэх, ёс зүйн талаар сургалтад хамруулах;

6.8.7.асран хамгаалагч, асралт гэр бүлийн байдалд байнгын тогтмол хяналт тавьж, ахмад настны сэтгэл ханамжийг үнэлэх.

6.9.Үнэлгээгээр 3 дугаар түвшний, шаардлагатай бол 2 дугаар түвшний гэртээ ганцаар үлдэх боломжгүй, оюуны ялгаатай хөгжил, сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай, зөнөгрөх өвчтэй, байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг төвд эсхүл өөрийн байранд 1 хоногоос 6 сар хүртэлх хугацаагаар буюу түр хугацаагаар байрлуулан 6 сараас 1 жил хүртэлх хугацаанд буюу урт хугацаагаар ахмад настны хэрэгцээнд тохирсон асаргаа, үйлчилгээг дараах хэлбэрээр үзүүлнэ:

6.9.1.ахмад настан, тэдний асран хамгаалагчдад түр болон урт хугацаанд үзүүлэх үйлчилгээг танилцуулж гэрээ байгуулан ажиллах;

6.9.2.түр болон урт хугацаагаар асрах хугацаа, үйлчлүүлэгчийн зохистой хооллолт, түүнд үзүүлэх үйлчилгээний төрөл, хэлбэрийг хэрэгцээ шаардлага, нөхцөл байдалд үндэслэн боловсруулж, хувь хүний хөтөлбөрийн дагуу асаргаа сувилгааны болон хөгжлийн үйлчилгээ үзүүлэх;

6.9.3.ахмад настны бие махбодь, эрүүл мэндийн байдал, асаргаа сувилгааны хэрэгцээнд тулгуурлан өдөр тутмын амьдралын үйл ажиллагаанд хэвийн оролцох боломжийг бүрдүүлэх, нийгэм сэтгэл зүй, хөгжлийн үйлчилгээг үзүүлэх;

6.9.4.ахмад настан, тэдний асран хамгаалагч, үйлчилгээ үзүүлэгч талуудтай хамтран тухайн үйлчилгээтэй холбоотой сайжруулах шаардлагатай асуудлуудыг тодорхойлж, улмаар зохих өөрчлөлтүүдийг хийх;

6.9.5.түр болон урт хугацааны асрах үйлчилгээний чанар, үр дүн, сэтгэл ханамжийг тогтмол үнэлэх, хөндлөнгийн хараат бус хяналтыг тавих;

6.9.6.түр болон урт хугацаагаар асрах үйлчилгээнд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа эрүүл мэндийн болон асрамжийн үйлчилгээний нийтлэг шаардлагыг дагаж мөрдөх.

6.10.Байнга асрах үйлчилгээ асрамжийн үйлчилгээнд хамрагдах хүсэлт гаргасан 3 дугаар түвшний, шаардлагатай тохиолдолд 2 дугаар түвшний ахмад настныг асрамжийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага хангасан байранд байнга байрлуулан сэтгэл зүй, нийгэм, соёл, хоол, хувцас, эрүүл мэндийн асаргаа сувилгаа үзүүлэх, тэдний амьдралын хэвийн нөхцөлийг бүрдүүлэх үйлчилгээ үзүүлнэ.

6.10.1.ахмад настан, тэдний асран хамгаалагчдад байнга асрах үйлчилгээг танилцуулж гэрээ байгуулан ажиллах;

6.10.2.байнга асруулах үйлчлүүлэгчийн зохистой хооллолт, түүнд үзүүлэх үйлчилгээний төрөл, хэлбэрийг хэрэгцээ шаардлага, нөхцөл байдалд үндэслэн боловсруулж, хувь хүний хөтөлбөрийн дагуу асаргаа сувилгааны болон хөгжлийн үйлчилгээ үзүүлэх;

6.10.3.ахмад настныг нэг ба түүнээс дээш жилийн хугацаанд өөрийн байрандаа байрлуулан нийгэм, соёл, хоол, хувцас, эрүүл мэнд, сэтгэл зүйн байдлыг дэмжиж, сэтгэл ханамжтай байрлуулах цогц үйлчилгээнд хамруулах;

6.10.4.ахмад настан, тэдний асран хамгаалагч, үйлчилгээ үзүүлэгч талуудтай хамтран тухайн үйлчилгээтэй холбоотой сайжруулах шаардлагатай асуудлуудыг тодорхойлж, улмаар зохих өөрчлөлтүүдийг хийх;

6.10.5.байнга асрах үйлчилгээний чанар, үр дүн, сэтгэл ханамжийг тогтмол үнэлэх, хөндлөнгийн хараат бус хяналтыг тавих;

6.10.6.байнга асрах үйлчилгээнд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа эрүүл мэндийн болон асрамжийн үйлчилгээний нийтлэг шаардлагыг дагаж мөрдөх.

6.11.Тэжээн тэтгэх хүүхэдгүй, бие даан амьдрах чадваргүй ганц бие, эсхүл тэжээн тэтгэх хүүхэд нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэйн улмаас дэмжлэг тусалцаа үзүүлэх чадваргүй, тэжээн тэтгэх үүрэгтэй этгээд нь тухайн ахмад настны эсрэг хүчирхийлэл үйлдсэн нь тогтоогдсон ахмад настныг Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу аймаг, дүүргийн Засаг даргын захирамжийг үндэслэн төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулна.

6.12.Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой журам, зардлын нормативыг Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5, 19.7, 19.8-д тус тус заасны дагуу нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, асрамжийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлагыг стандартчилал, хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага баталж, мөрдүүлнэ.

6.13. Ахмад настны тухай хуулийн 7.1.9-д заасан ахмад настны гэр бүлийн хүчирхийлэлд өртөх эрсдлийг бууруулах, сургалт сурталчилгаа хийх, гэр бүлийн гишүүдэд сургалт хийх, зөвлөгөө өгөх зэрэг үйл ажиллагааг Асаргааны хувилбарт үйлчилгээ үзүүлж байгаа байгууллага, иргэн энэ журмын 5 дугаар зүйлийн 5.10-аас 5.12-т заасны дагуу үзүүлнэ.

6.14.Сум, хорооны нийгмийн ажилтан асаргааны хувилбарт үйлчилгээнд хамрагдах 3 дугаар түвшний, шаардлагатай тохиолдолд 2 дугаар түвшний ахмад настныг энэ журмын 3.5-д заасны дагуу лавшруулан үнэлээд, асаргааны тохирох хувилбарт үйлчилгээнд хамруулахаар улс, орон нутгийн асрамжийн газар,

асаргааны хувилбарт үйлчилгээ үзүүлэхээр гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагад шилжүүлнэ.

6.15.Ахмад настан эсхүл асран хамгаалагч асаргааны хувилбарт үйлчилгээнд хамрагдахад дор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ:

6.15.1.өргөдөл (ахмад настны эсхүл асран хамгаалагчийн) ;

6.15.2.ахмад настны цогц үнэлгээний хуудасны хуулбар (цаасан эсхүл цахим);

6.15.3.иргэний үнэмлэхийн хуулбар (цахим);

6.15.4.Ахмад настны тухай хуулийн 7.2.11-т заасан ахмад настны асарч байгаа иргэний эрүүл мэнд болон ачааллыг үнэлсэн үнэлгээний дүгнэлт.

6.16.Ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээг хэрэгжүүлэхэд нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтан дараах үүргийг хүлээнэ:

6.16.1.иргэдэд асаргааны хувилбарт үйлчилгээний талаар мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;

6.16.2.асаргааны хувилбарт үйлчилгээг үзүүлэх хүсэлтэй хуулийн этгээдийн нэгдсэн бүртгэл, судалгаа хөтлөх;

6.16.3.асаргааны хувилбарт үйлчилгээ үзүүлж буй байгууллага, иргэний үйл ажиллагаанд хяналт тавих, хөндлөнгийн хараат бус хяналтыг зохион байгуулах;

6.16.4.асаргааны хувилбарт үйлчилгээ үзүүлэгч болон уг үйлчилгээнд хамрагдсан ахмад настны талаар мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх;

6.16.5.асаргааны хувилбарт үйлчилгээнд хамрагдаж байгаа ахмад настны санал, хүсэлт, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх тогтолцоо бүрдүүлэх;

6.17.Өрхийн эрүүл мэндийн төв дараах үүрэг хүлээнэ:

6.17.1.ахмад настны цогц үнэлгээний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, ашиглах;

6.17.2.энэ журмын 3.5-д заасан үнэлгээнд үндэслэн сум, тосгон, өрхийн эмнэлэгээс өдрөөр эмчлэх, асрах сувилах үйлчилгээ үзүүлэх, сэргээн засах үйлчилгээ үзүүлэх;

6.17.3.ахмад настны эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг гаргаж өгөх;

6.17.4.ахмад настанд сэргээн засах үйлчилгээг асаргааны хувилбарт үйлчилгээний байгууллагатай гэрээгээр болон төвөөр үзүүлэх;

6.17.5.ахмад настныг хувилбарт үйлчилгээнд хамруулах хугацаанд шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн шуурхай тусламж, үйлчилгээг үзүүлэх;

6.17.6.урьдчилан төлөвлөх боломжгүй гамшиг, онцгой байдал, цар тахал, бусад эрсдэлийн үед ахмад настны талаар хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамж, аюулгүйн төлөвлөгөөний заавар өгөх.

6.18.Үнэлгээгээр 3 дугаар түвшний шаардлагатай бол 2 дугаар түвшний дараах ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээний зардлыг нийгмийн халамжийн сангаас хөнгөлөлттэй болон бүрэн хариуцна:

6.18.1.асран хамгаалах, харгалзан дэмжих төрөл, садангүй бөгөөд бие даан амьдрах чадваргүй, ганц бие, байнгын эмчилгээ, асаргаа шаардлагатай ахмад настан;

6.18.2.асран хамгаалах, харгалзан дэмжих гэр бүл, төрөл, садантай боловч тэдгээр нь асрах халамжлах боломжгүй нь тогтоогдсон нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай ахмад настан;

6.18.3.тэжээн тэтгэх үүрэгтэй этгээд нь тухайн ахмад настны эсрэг хүчирхийлэл үйлдсэн нь тогтоогдсон ахмад настан.

6.19.Энэ журмын 6.18-д зааснаас бусад ахмад настан амьжиргааны түвшин, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ зэргээс хамааран асаргааны хувилбарт үйлчилгээнд төлбөртэй эсхүл төлбөрийн хөнгөлөлттэй нөхцлөөр хамрагдана.

6.20.Асаргааны хувилбарт үйлчилгээг төрийн байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар дамжуулан төлбөртэй, төлбөрийн хөнгөлөлттэй, төлбөргүй нөхцөлөөр үзүүлэхэд нийгмийн хамгааллын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтран баталсан үйлчилгээний жишиг үнэ болон иргэний хариуцах төлбөрийн хэмжээг баримтална.

6.21.Асаргааны хувилбарт үйлчилгээ үзүүлэх байгууллага, иргэн нь тухайн байгууллагын орон тоо, хүний нөөцийн чадавх, барилга байгууламжийн багтаамж зэргээс хамааран энэ журмын 6.3-т заасан үйлчилгээг дангаар, зарим төрлийг, цогцоор үзүүлж болно.

6.22.Ахмад настны тухай хуулийн 7.1.3-т заасан явуулын үйлчилгээг энэ журмын 6.4-т заасны дагуу, Ахмад настны тухай хуулийн 7.1.4-т заасан өдрийн үйлчилгээг энэ журмын 6.5-т заасны дагуу хэрэгжүүлнэ.

6.23.Энэ журмын 5 дугаар зүйлд заасан Идэвхтэй насжилтийг дэмжих төвийн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллага, иргэн нь асаргааны хувилбарт үйлчилгээ болон Ахмад настны тухай хуулийн 7.1.3, 7.1.4-т заасан үйлчилгээг орон тоо, хүний нөөцийн чадавх, барилга байгууламжийн багтаамж зэргээс хамааран цогцоор үзүүлж болно.

Долоо. Ахмад настанд үзүүлэх өдрөөр эмчлэх, сувилах үйлчилгээ

7.1.Өдрийн эмчилгээ, сувилгаа шаардлагатай ахмад настанд Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан “Өдрийн эмчилгээний журам”-ын дагуу өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв болон лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллага үзүүлэх ба өвчний түүх нээн, тусламж үйлчилгээг амбулаториор үзүүлнэ.

7.2.Ахмад настны цогц үнэлгээгээр 3 дугаар түвшний шаардлагатай бол 2 дугаар түвшний ахмад настанд гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээг өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс Эрүүл мэндийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний баталсан удирдамж зааврын дагуу үзүүлнэ.

7.3.Ахмад настанд өдрөөр эмчлэх, сувилах үйлчилгээний зардлын төлбөрийг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3, 9.1.9-д заасны дагуу эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцна.

Найм. Ахмад настанд үзүүлэх сэргээн засах тусламж, үйлчилгээ

8.1.Ахмад настны сэргээн засах тусламж, үйлчилгээний зорилго нь ахмад настанд сэргээн засахын цогц тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэхэд оршино.

8.2.Ахмад настны сэргээн засах тусламж, үйлчилгээг төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, сувилал, энэ үйлчилгээг үзүүлдэг бусад байгууллага үзүүлнэ.

8.3.Ахмад настанд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс тогтоосон “Эрүүл мэндийн даатгалаас төлбөрийг хариуцах эмнэлгийн тусламж үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалт төлбөрийн хэмжээ”-нд заасны дагуу уламжлалт болон сэргээн засахын эмчилгээг хослуулан үзүүлнэ.

8.4.Ахмад настанд сэргээн засах тусламж, үйлчилгээг үзүүлэхдээ Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан Сэргээн засах тусламж, үйлчилгээний журамд заасан хэлбэр, дараалал, хугацаа, давтамж зэргийг баримтална.

8.5.Ахмад настанд үзүүлэх сэргээн засах тусламж, үйлчилгээг өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв өдрөөр, лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагууд амбулаториор, өдрөөр, хэвтүүлэн эмлэх хэлбэрээр үзүүлнэ.

8.6.Ахмад настны архаг өвчний хүндрэл, дахилт, хоёрдогч эмгэг үүсэхээс урьдчилан сэргийлж, эмчилгээний төлөвлөгөөг сэргээн засах судлалын эмч мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллана.

8.7.Ахмад настныг сэргээн засах эмчилгээний төлөвлөгөөнд курс эмчилгээ, давтан үзлэг, эмчилгээний үе шаттай хуваарь, эмч мэргэжилтний тоо, тусламж үйлчилгээний дараалал зэргийг тусгасан байна.

8.8.Сэргээн засах тусламж, үйлчилгээний баг нь сэргээн засах эмчилгээний эмч, сувилагч, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, хоол засалч, ахуй засалч, хэл засалч, хоол зүйч, алхаа гишгээ, тэнцвэр үнэлэх нуруу баганын эмгэг илрүүлэх хөлний эмч зэрэг тухайн эмгэгээс хамаарсан 2-оос 4 хүртэлх тооны мэргэжилтэнтэй байна.

8.9.Ахмад настны хэрэгцээнээс хамаарч сэргээн засах тусламж, үйлчилгээг мэргэжлийн эмч, сувилагч багаар үзүүлнэ.

Ес. Ахмад настны цогц тусламж үйлчилгээнд тавих хяналт, тайлагналт

9.1.Ахмад настны цогц тусламж, үйлчилгээний хэрэгжилт, төсөв, хөрөнгийн зарцуулалтад аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон төрийн захиргааны төв байгууллага тус тус хяналт тавина.

9.2.Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ журмын 5,6 дугаар зүйлд заасан үйлчилгээнд хамрагдсан ахмад настны болон үйлчилгээ үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын мэдээллийн санг бүрдүүлэх, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4.1.1-д заасан мэдээллийг ашиглан үйлчилгээг цахимжуулах, хяналт үнэлгээ хийх, санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн бодитой олгох арга хэмжээг хэрэгжүүлнэ.

9.3.Эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ журмын 7,8 дугаар зүйлд заасан тусламж үйлчилгээнд хамрагдсан ахмад настны болон тусламж, үйлчилгээ үзүүлсэн байгууллагын мэдээллийн сан бүрдүүлэх, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4.1.1-д заасан мэдээллийг ашиглан үйлчилгээг цахимжуулах, хяналт үнэлгээ хийх, санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн бодитой олгох арга хэмжээг хэрэгжүүлнэ.

9.4.Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагаас үйлчилгээнд хамрагдсан ахмад настны талаарх холбогдох мэдээ, тайланг гаргуулан авч нэгтгэн нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хагас жил болон жилийн эцэст хүргүүлнэ.

9.5.Хуурамчаар баримт бичиг үйлдсэн өрх, иргэн, хуулийн этгээд, түүнчлэн үйлчилгээнд хамрагдсан ахмад настныг буруу үнэлсэн, үндэслэлгүй буюу хуурамч дүгнэлт гаргасан, халамжийн, эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан албан тушаалтанд Ахмадын тухай хуулийн 16 дугаар зүйлд, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

9.6.Үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь ахмад настны цогц тусламж үйлчилгээний хууль тогтоомж болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, тайлан мэдээг худал мэдээллэсэн, ахмад настны эрх ашгийг хохироосон тохиолдолд аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагаас гэрээг цуцлах шийдвэр гаргана.

“Ахмад настанд цогц үнэлгээ хийх, тусламж, үйлчилгээ үзүүлэх журам”-ын хавсралт

АХМАД НАСТНЫ ЦОГЦ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТИЙН ЗАГВАР

<p>Эрүүл мэндийн байгууллагын нэр:.....</p> <p>Үнэлгээ хийсэн: Эмнэлгийн мэргэжилтний нэр.....</p> <p>Огноо:он.....сар... өдөр....цаг...минут</p>			
<p>Овог Нэр..... Нас.....</p> <p>РД</p> <p>Хаяг:</p> <p>Асран халамжлагчийн нэр: Харилцах утас:</p> <p>Боловсрол: Эрхэлж байсан ажил:</p>			
Үндсэн зовиур			
Өвчний түүх			
Тогтмол уудаг эм			
Илгээсэн эрүүл мэндийн байгууллага			
Хам шинж	1 дүгээр түвшин	2 дугаар түвшин	3 дугаар түвшин
Танин мэдэхүйн чадвар бууралтын үнэлгээ			
Хөдөлгөөний чадвар бууралтын үнэлгээ			
Хоол тэжээлийн бууралтын үнэлгээ			
Харааны чадвар бууралтын үнэлгээ			
Сонсголын чадвар бууралтын үнэлгээ			
Сэтгэл гутралын үнэлгээ			
Цогц үнэлгээний			

дүгнэлт			
<p>Хувь хүний цогц тусламж, үйлчилгээний төлөвлөгөө</p>	<ol style="list-style-type: none"> 1. Зөвлөгөө мэдээлэл 2. Идэвхтэй насжилтын төв 3. Ахмадын хөгжлийн төв 	<ol style="list-style-type: none"> 1. Төрөлжсөн мэргэшлийн эмч мэргэжилтэн 2. Хүндрэх эрсдэлээс сэргийлэх 3. Туслах хэрэгсэл 4. Нийгмийн халамжийн дэмжлэг 5. Асран хамгаалагч, гэр бүлийн оролцоо 6. Идэвхтэй насжилтын төв 7. Ахмадын хөгжлийн төв 	<ol style="list-style-type: none"> 1. КАТЗ-ын үнэлгээ 2. ЛАВТОН-ы үнэлгээ 3. ЗАРИТ-ын асуумж 4. Нийгмийн тусламж, үйлчилгээний хэрэгцээний үнэлгээ 5. Лавшруулан оношлох 6. Туслах хэрэгсэл 7. Нийгмийн халамжийн дэмжлэг <p>Асран хамгаалагч, гэр бүлийн оролцоо</p> <p>Асаргааны хувилбарт үйлчилгээ</p>
<p>Эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн тусламж үйлчилгээ</p>			
<p>Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн хяналтын дүгнэлт /эпикриз/</p>			
<p>Эцсийн дүгнэлт хийгдсэн огноо:</p>			
<p>Дүгнэлт гаргасан: эмчийн гарын үсэг, тамга, тэмдэг нийгмийн ажилтны гарын үсэг, тамга, тэмдэг</p>			

Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын болон Эрүүл мэндийн сайдын 2024 оны .. дугаар сарын ...-ны өдрийн хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралт

АХМАД НАСТАНД ҮЗҮҮЛЭХ ЦОГЦ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ МЭРГЭЖЛИЙН УДИРДЛАГААР ХАНГАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Ахмад настны тухай хуульд заасны дагуу ахмад настны цогц үнэлгээ хийж, цогц тусламж үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтныг мэргэшүүлэх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн удирдлагаар хангахад энэхүү журмыг мөрдөнө.

Хоёр.Удирдлага, зохион байгуулалт

2.1.Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан үйлчилгээг хэрэгжүүлэхэд салбар дундын үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтныг мэргэжил арга зүйн удирдлагаар хангахад дэмжлэг үзүүлэх, чиглүүлэх үүрэг бүхий Удирдах хороог нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний дэргэд ажиллуулна.

2.2.Удирдах хороо нь дараах бүрэлдэхүүнтэй байна:

2.2.1.Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

2.2.2.Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга;

2.2.3.Монголын ахмадын холбооны ерөнхийлөгч;

2.2.4.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга;

2.2.5.Геронтологийн үндэсний төвийн захирал;

2.2.6.Нийгмийн ажлын мэргэжлийн холбооны тэргүүн;

2.2.7.Эрүүл мэндийн нийгмийн ажилтны нийгэмлэгийн тэргүүн;

2.2.8.Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуулийн захирал;

2.2.9.Эмч, эмнэлгийн ажилтны нийгэмлэгийн тэргүүн, нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй байна.

2.3.Удирдах хорооны шийдвэрийг хэрэгжүүлэх, өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулах үүрэг бүхий Ажлын албатай байна.

2.4.Ажлын алба нь нь дараах бүрэлдэхүүнтэй байна:

2.4.1.Эрүүл мэндийн яамны Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эрүүл мэндийн бодлого хариуцсан нэгжийн дарга;

2.4.2.Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн асуудал хариуцсан нэгжийн дарга;

2.4.3.Монголын ахмадын холбооны дэд ерөнхийлөгч;

2.4.4.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Нийгмийн халамжийн асуудал хариуцсан нэгжийн дарга;

2.4.5. Геронтологийн үндэсний төвийн Эрдэм шинжилгээ, сургалтын ажиллагааны албаны дарга, нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй байна.

2.5.Ажлын албаны нарийн бичгийн дарга нь Геронтологийн үндэсний төвийн ахмад настны сургалт хариуцсан чиг үүрэг бүхий мэргэжилтэн байна.

2.6.Удирдах хороо нь дараах чиг үүрэгтэй ажиллана:

2.6.1.Монгол Улсад ахмад настны цогц тусламж, үйлчилгээний шинэлэг тогтолцоо бий болгоход орон нутгийн удирдах хороонд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх;

2.6.2.үйл ажиллагааны төлөвлөгөөний алсын хараа, эрхэм зорилго, зарчмууд орон нутгийн ахмад настны үйлчилгээний төлөвлөгөөтэй уялдаж байгаа эсэхийг хянах;

2.6.3.хэрэгжилтийг хангах нөөцийг тодорхойлох, хөрөнгө хуваарилах зэрэгт дэмжлэг үзүүлэх;

2.6.4.хүний нөөцийг хөгжүүлэх, ажлын байранд тогтвор суурьшилтай ажиллуулахад чиглэсэн төлөвлөгөөг боловсруулан батлах;

2.6.5.үнэлгээний үндэсний тогтолцоог хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, шалгуур, журам аргачлалыг шинэчлэх, хянах, үр дүнг тогтмол хэмжихэд дэмжлэг үзүүлэх;

2.6.6.үйлчилгээг өргөжүүлэхэд иргэн, аж ахуй нэгж, төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагыг татан оролцуулахад дэмжлэг үзүүлэн ажиллах;

2.6.7. үйл ажиллагааны талаарх үндэсний болон орон нутгийн тайлан, идэвхтэй насжилтын төвүүдийн үйл ажиллагааны тайлан зэргийг хянаж, шаардлагатай үед саналаа хүргүүлэх;

2.6.8.үйлчилгээг хөгжүүлэх, хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар, бүс нутаг, салбар хоорондын хамтын ажиллагааг харилцан зөвшилцөж, хэлэлцэх;

2.6.9.төвийн ажилтнуудыг сургах төлөвлөгөө гарган, сургалтыг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх;

2.6.10.төвийн ажилтнуудын нийгмийн баталгааг хангахад анхаарч ажиллах.

2.7.Удирдах хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

2.8.Удирдах хороо нь жилд 2-оос доошгүй удаа хуралдах бөгөөд шаардлагатай тохиолдолд тухай бүр хуралдана. Хуралдааныг цахим болон танхимын хэлбэрээр зохион байгуулж болно.

2.9.Аймаг, дүүрэгт аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, хөдөлмөр, халамжийн үйлчилгээний байгууллага, ахмадын холбооны төлөөллийг оролцуулсан 5 хүний бүрэлдэхүүнтэй Орон нутгийн удирдах хороог тухайн аймаг, дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулна. Орон нутгийн удирдах хороог аймаг, дүүргийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга удирдана.

2.10.Орон нутгийн удирдах хороо нь өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтны ахмад настанд үзүүлэх үйлчилгээ, урт хугацааны тусламж, үйлчилгээ түүний дотор идэвхтэй насжилтын төвүүдийг орон нутагт хөгжүүлэх, хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлж, чиглүүлж ажиллана.

Гурав.Байгууллагуудын чиг үүрэг

3.1.Ахмад настанд цогц тусламж, үйлчилгээг үзүүлэхэд оролцох байгууллагууд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1.Геронтологийн үндэсний төв

3.1.1.1.ахмад настны цогц тусламж үйлчилгээг үндэсний хэмжээнд мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах;

3.1.1.2.ахмад настанд цогц тусламж үйлчилгээ үзүүлэх мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтыг үндэсний хэмжээнд зохион байгуулах;

3.1.1.3.цогц тусламж үйлчилгээний заавар болон холбогдох бусад баримт бичиг, заавар, журмыг боловсруулах;

3.1.1.4.шаардлагатай тохиолдолд цахимаар сургалт, зөвлөгөө өгч ажиллах;

3.1.2.аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар

3.1.2.1.аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь ахмадын цогц тусламж үйлчилгээг удирдлагаар хангах орон тооны мэргэжилтэн ажиллуулах;

3.1.2.2.харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд ахмад настанд үзүүлэх цогц тусламж үйлчилгээг хөдөлмөр, нийгмийн хамгааллын байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

3.1.3.Лавлагаа төв, эмнэлэг

3.1.3.1.архаг, хавсарсан өвчтэй ахмад настныг лавлагаа төв, эмнэлэг нь тусламж үйлчилгээний үндсэн чиглэлийн дагуу хүлээн авч, өрх, сум, тосгоны эмчтэй хамтран эмчлэн эрүүлжүүлэх төлөвлөгөөг боловсруулан урт хугацааны тусламж үйлчилгээг хамтран хэрэгжүүлэх;

3.1.3.2.лавлагаа төв, эмнэлэг нь тусламж, үйлчилгээний үндсэн чиглэлийн урт хугацааны тусламж үзүүлэх төлөвлөгөөнд эргэн хяналтын хугацааг тодорхой зааж, үйлчлүүлэгчийн биеийн байдал сайжирч үр дүн өгч буй тохиолдолд хяналт, зааврыг цахимаар өгч хэрэгжүүлж болно.

3.1.4.Ахмадын хөгжлийн төв, идэвхтэй насжилтын төв

3.1.4.1. ахмад настны цогц үнэлгээгээр 1, 2 дугаар түвшинд үнэлэгдсэн ахмад настныг эрүүл байдлаа хадгалахыг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж, ахмадын хамралтыг тогтмол нэмэгдүүлэх;

3.1.4.2.үйл ажиллагааны чадвар буурч эхэлж буй ахмад настнуудыг нийгэм хамт олонд тулгуурласан сэргээн засах үйлчилгээнд хамруулах;

3.1.4.3.байнгын асаргаа шаардлагатай ахмад настанд гэрээр, өдрөөр, урт болон богино хугацааны асаргааны үйлчилгээг холбогдох хууль, журмын хүрээнд үзүүлэх.

3.1.5. Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн газар, хэлтэс

3.1.5.1.аймаг, дүүргийн ахмадын судалгааг нарийвчлан гаргах;

3.1.5.2.ахмад настанд шаардлагатай дэмжлэг үйлчилгээний талаар санал боловсруулж аймаг, дүүргийн удирдлагад уламжлах;

3.1.5.3.сум, хорооны нийгмийн ажилтныг удирдлага арга зүйгээр хангах, дэмжиж ажиллах.

3.1.6.Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв

3.1.6.1.ДЭМБ-ын зөвлөмж, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/22-р тушаалаар батлагдсан “Ахмад настны цогц тусламж үйлчилгээ -ICOPE”-ийн үнэлгээний зааврыг хэрэгжүүлэхэд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн хангалтыг хийсэн байх;

3.1.6.2.“Ахмад настны цогц тусламж үйлчилгээ -ICOPE”-ний үнэлгээний сургалтад эмч, сувилагч нарыг хамруулах, сургагдсан эмч мэргэжилтнээр хангагдсан байх;.

3.1.6.3.“Ахмад настны эрүүл мэндийн цогц үнэлгээ-ICOPE”-г Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд эмч, сувилагч, эрүүл мэндийн нийгмийн ажилтан хийх;

3.1.6.4.өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд “Ахмад настны цогц тусламж үйлчилгээ -ICOPE”-ийн үнэлгээг жилд нэг удаа ахмад настан бүрт хийх;

3.1.6.5 ахмад настны цогц үнэлгээгээр 1, 2 дугаар түвшинд үнэлэгдсэн ахмад настанд эрүүл мэндийн зөвлөгөө өгч, хянах;

3.1.6.6.“Ахмад настны цогц тусламж үйлчилгээ-ICOPE”-ийн үнэлгээгээр лавшруулан оношлох шаардлагатай үнэлэгдсэн ахмад настныг алгоритмын дагуу эмч үнэлэн холбогдох лавлагаа шатлалын төвд цогц үнэлгээний дүгнэлтийг илгээн, тусламж, үйлчилгээний төлөвлөгөө боловсруулан эрүүлжүүлэх арга хэмжээ авах.

3.1.7.Сум, хорооны нийгмийн ажилтан

3.1.7.1.сум хорооны нийгмийн ажилтан нь ахмад настанд нөхцөл байдлын үнэлгээ хийх;

3.1.7.2.нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах талаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллах;

3.1.7.3.шаардлагатай нийгмийн үйлчилгээнд холбон зуучлах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3.1.7.4.орон нутгийн дэмжлэгийн нөөцийг судлах, хөрөнгө бүрдүүлэх ажилд ахмадын байгууллагатай хамтран арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллана.

Дөрөв.Мэргэжлийн удирдлагыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1.Мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүргийг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

4.1.1.орон нутгийн удирдах хороо нь харьяа өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтныг мэргэжлийн удирдлагаар хангахад шаардлагатай зардлын дэмжлэгийг Удирдах хороогоор шийдвэрлүүлэх, үйл ажиллагааг чиглүүлэх ажлыг хариуцан гүйцэтгэнэ.

4.1.2.ахмад настанд цогц тусламж, үйлчилгээ үзүүлэхээр гэрээ байгуулан ажиллаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтныг мэргэжлийн удирдлагаар хангах ажлыг орон нутгийн удирдах хороо, эрүүл мэндийн болон нийгмийн ажилтны мэргэжлийн холбоод хамтран холбогдох эрх, үүргийн хүрээнд хэрэгжүүлэн ажиллана.

4.2.Орон нутгийн удирдах хороо нь өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, гэрээ байгуулан ажиллаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтныг мэргэжлийн удирдлагаар хангах дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.2.1.мэргэшүүлэн сургах;

4.2.2.үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх;

4.2.3.мэргэжил арга зүйгээр дэмжих.

4.3.Мэргэшүүлэн сургах үйл ажиллагааг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

4.3.1.мэргэжил олгох урт, дунд, богино хугацааны сургалтад хамруулах;

4.3.2.ахмад настны насжилт, настны эрүүл мэндийг дэмжих сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах;

4.3.3.мэргэжлийн үнэ цэнийг бий болгох,

4.3.4.мэдлэг олгох, практик дадлага хийх ур чадварыг сургах

4.3.5.ажилтнуудын өөрийгөө сайтар таньж мэдэх, мэдрэмжтэй ажиллах байдлыг дэмжих.

4.4.Үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

4.4.1.үйлчилгээний стандарт зааврыг мөрдөж ажиллах

4.4.2.үйлчилгээний зорилго, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох,

4.4.3.чиг үүргийг тодруулах,

4.4.4.ажлыг төлөвлөх, хуваарилах, хянах, үнэлэх,

4.4.5.удирдлагын зүгээс ажлын үүрэг, хариуцлага хүлээх

4.4.6.үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах чиглэлийг тодорхойлох, дэмжлэг үзүүлэх;

4.4.7.үйл ажиллагааг уялдуулан зохицуулах салбар хоорондын зохицуулалтыг хийх;

4.4.8.ажил үүрэгтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэх,

4.4.9.ажлын үр дүнтэй гүйцэтгэлд нөлөөлөх хандлага, мэдрэмжийг хөгжүүлэх

4.4.10.ажилтнуудын ёс зүйтэй байдлыг хангаж, ажилтнуудад мэргэжлийн хувьд өөрийгөө үнэлэх мэдрэмжийг нэмэгдүүлэх.

4.4.11.үйл ажиллагаа зохион байгуулах зардлын болон бусад дэмжлэг.

4.4.12.ахмад настны статистик мэдээ, судалгаа, кейсийн бүртгэлд үндэслэн үйлчилгээний төлөвлөгөө хэтийн боловсруулах

4.4.13.төвийн ажилтан, албан хаагч нартай уулзалт зохион байгуулж ахмад настны чиглэлээр хэрэгжиж буй хууль, дүрэм, журам, заавар зөвлөмжийг танилцуулах, сурталчлах,

4.4.14.ажилтны хийж хэрэгжүүлсэн ажлыг үнэлэх, дүгнэх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар чиглэл, заавар өгөх,

4.4.15.төвийн үйл ажиллагааны үйлчилгээний чанарт хийсэн үнэлгээнд үндэслэн цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах

4.5.Мэргэжил арга зүйгээр дэмжих үзүүлэх үйл ажиллагааг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

4.5.1.бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай зөвлөх үйлчилгээ авах, мэргэжлийн баг ажиллуулах;

4.5.2.ажилтанд хүнд, архагшсан кейс дээр ажиллахад зөвлөн туслах

4.5.3.ажлаас халшрах хам шинжийг таних, даван туулахад дэмжлэг үзүүлэх

4.5.4.ажилтны ажлын сэтгэл ханамжийг дээшлүүлэх, тогтвортой ажиллуулахад анхаарах.

4.5.5.ажилтныг ажлын байран дээр зөвлөн туслах, дэмжих

4.5.6.холбон зуучлах үйлчилгээний зураглал гаргахад хамтран ажиллах,

Тав.Бусад

5.1.Мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий ажилтан нь мэргэжлийн ёс зүй, хил хязгаарыг чанд баримтлан ажиллана.

5.2.Ажлын болон мэргэжлийн ёс зүйн алдаа дутагдал гаргасан ажилтанд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.

5.3.Мэргэжлийн удирдлагаар хангахдаа олж мэдсэн хувь хүний нууцыг задруулахгүй байх үүргийг хүлээнэ.

---oOo---